



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/21

Модот

Комисс томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.1 дэх заалт, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Аяга таваг угаагч автомат машин нийлүүлэх ерөнхий боловсролын сургууль”-ийн жагсаалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Боловсролын Дэлхийн түншлэл олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хүрээнд “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай автомат аяга таваг угаагч худалдан авах, нийлүүлэх(угсралт, суурилуулалт, хүргэлт)” СХОГ-2025/221 тоот гэрээний дагуу “Дельфин партнерс” ХХК-аас нийлүүлсэн автомат аяга таваг угаагчийг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Өсөхцэнгэл –	Бага ангийн багш
Нарийн бичгийн дарга: Г.Золбоо	Нярав
Гишүүд:	Л.Ариунтунгалаг Нягтлан бодогч
	О.Жавзмаа Архив, бичиг хэргийн ажилтан
	Д.Одонтуяа Тогооч

2. Автомат аяга таваг угаагчийг хүлээн авах ажлыг зохион байгуулж, удирдлагаар ханган, бараа хүлээн авсан баримтыг санхүүгийн баримт бичгийн шаардлагын дагуу бүрэн гүйцэт бүрдүүлж, баталгаажуулах үйл явцад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга (М.Өсөхцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ